



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/149/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Сайншанд сум  
2020 он

Дарга, тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a>
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: <a href="mailto:enktsetseg.e@audit.gov.mn">enktsetseg.e@audit.gov.mn</a>
Ахлах аудитор:	Ц.Лүндэгмаа
	Цахим хаяг: <a href="mailto:lundegmaa.ts@audit.gov.mn">lundegmaa.ts@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭМНДШ	Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
	2.1 Оршил .....	5
	2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
	2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
	2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
	2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
	2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
	2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
	2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7-9
	2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
	2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил .....	9-11
	2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
	2.13 Шилэн дансны мэдээлэл.....	11
	2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	11
	2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12-13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14-19

## 1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2020.01.31 № 1-6/42

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ  
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.НЯМСҮРЭН  
ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хэлтсийн дарга, ахлах шийдвэр гүйцэтгэгч Ц.Нямсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.27-аас 2020.01.30-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.01.31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох, ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.23-ны өдрийн 01/31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зурамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд зааснаар зохион байгуулж, хууль ёс, сахилга дэг журам, ил тод байдлыг дээдлэн хуульч ажиллагааг, соёлч харилцааг эрхэмлэн хүнд сурталгүй шуурхай ажиллах зарчмыг баримтална” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны А/01 тоот тушаалаар 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг “Сахилга хариуцлага, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх” зорилт дэвшүүлж зорилтын хүрээнд дараах дэд зорилтуудыг тавьж ажиллажээ. Үүнд:

- Алба хаагчдын харилцаа, ажилдаа хандах хандлага, үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх
- Алба хаагчдын мэдлэг, сургалтын чанар, үр дүнг сайжруулах
- Ажлын байрны сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх
- Байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажиллагааг улам боловсронгуй болгох
- Санхүүгийн сахилга батыг сайжруулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудал горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 153,813.3 мянган төгрөгөөс тооцон 1538.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1538.1 мянган төгрөгөөр тооцсон болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 407.9 мянган төгрөгөөр байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	428.6	554.5	125.9
Урьдчилгаа /үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа/	0.0	4,600.0	4,600.0
Бараа материал	12,667.4	13,834.5	1,167.1
Үндсэн хөрөнгө	196,872.8	191,387.7	-5,485.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>209,968.8</b>	<b>210,376.7</b>	<b>407.9</b>
Өр төлбөр	326.9	46.7	-280.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	209,641.9	210,330.0	688.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>209,968.8</b>	<b>210,376.7</b>	<b>407.9</b>

Авлага дансны эхний үлдэгдэл хувь хүмүүсээс авах авлага 428.6 мянган төгрөгийг ажиллагсдын цалин хөлснөөс суутгаж барагдуулсан байна. Тайлант хугацаанд НДХ-т эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 554.5 мянган төгрөгөөр илүү төлснөөс шалтгаалж авлагын эхний үлдэгдлээс 125.9 мянган төгрөгөөр авлагын дүн өссөн байна.

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 4600.0 мянган төгрөг байгаа нь байгууллагын гадна жагсаалын талбай барьж байгуулах 4600.0 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхдээ 2750.0 мянган төгрөгийн зиг заг хавтанг материалын дансанд орлогодож, зарцуулсан, 650.0 мянган төгрөгийн тээврийн зардал, 1200.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэсний хөлсийг тус тус шууд зардалд бичсэн байв.

Энэ нь “Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхөөр бэлтгэж буй үндсэн хөрөнгийн зүйлийг эхлээд өртгөөр нь үнэлэх ёстой. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, тээврийн ба ачиж буулгах зардал, бэлтгэх суурилуулах тохируулахтай холбогдон гарсан зардал, бүх төрлийн татвар хураамж зэргээс бүрдэнэ” гэсэн УСНББОУС 17-г зөрчиж байна.

Иймд байгууллагын гаднах зам талбайг үндсэн хөрөнгөнд бүртгэх тухай хүсэлтээ ШШГЕГ болон ТӨХ-нд хүргүүлж шийдвэрлүүлэх хүртэл үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансанд бүртгүүлж залруулсантай холбоотой болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 1167.1 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 472.1 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 229.0 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 466.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5485.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 10796.4 мянган төгрөгөөр байгуулсан, 4426.3 мянган төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авч бүртгэсэн, бусад хангамжийн материал данснаас үндсэн хөрөнгийн шинжтэй 885.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж бүртгэсэн зэргээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 280.2 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдэл 326.9 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгийг барагдуулсан, 46.7 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг шинээр үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 210,330.0 мянган төгрөг болж 688.1 мянган төгрөгөөр өссөн нь 688.1 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүн бий болсноос шалтгаалжээ.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллага нь орлого төвлөрүүлэх үйл ажиллагаа явуулдаггүй тул орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 150,231.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 100 хувь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 150,231,6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэл 150,231.6 мянган төгрөг байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 50 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 117,585.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 117,031.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 554.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар 554.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 554.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

Тус байгууллага 2019 онд Нийгмийн даатгалын хэлтэст Эрүүл мэндийн даатгалын шимтгэл 554,500.06 төгрөг илүү төлж авлага үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 20.2.5 заалт, Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Байгууллагын гадна жагсаалын талбай барьж байгуулах 4600.0 мянган төгрөгийн ажлыг Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан бөгөөд 2750.0 мянган төгрөгийн зиг заг хавтанг

материалын дансанд орлогодож, зарцуулсан, 650.0 мянган төгрөгийн тээврийн зардал, 1200.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэсний хөлсийг тус тус шууд зардалд бичсэн байна.

Энэ нь “Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхөөр бэлтгэж буй үндсэн хөрөнгийн зүйлийг эхлээд өртгөөр нь үнэлэх ёстой. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, тээврийн ба ачиж буулгах зардал, бэлтгэх суурилуулах тохируулахтай холбогдон гарсан зардал, бүх төрлийн татвар хураамж зэргээс бүрдэнэ” гэсэн УСНББОУС 17-г зөрчиж байна.

Иймд байгууллагын гаднах зам талбайг үндсэн хөрөнгөнд бүртгэх тухай хүсэлтээ ШШГЕГ болон ТӨХ-нд хүргүүлж шийдвэрлүүлэх хүртэл үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансанд бүртгүүлж залруулав.

2. Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бусад хангамжийн материалын дансанд бүртгэсэн байна. Тухайлбал бусад хангамжийн материалын дансны оны эхний үлдэгдэлд 885.0 мянган төгрөгийн гүйлтийн зам бүртгэлтэй байсан бөгөөд 4426.4 мянган төгрөгийн 3 хөрөнгийг тайлант хугацаанд шинээр орлогод авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн зааварт “Хангамжийн материал нь төсөвт байгууллагын ажил үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд, цаашид зардал болох бичиг хэргийн материал, аж ахуйн зориулалттай материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун зэрэг хангамжийн шинжтэй бүх төрлийн бараа материалыг энэ дансанд бүртгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд үндсэн хөрөнгийн шинж чанартай 5311.4 мянган төгрөгийн 4 хөрөнгийг бусад хангамжийн материалын данснаас хасаж машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэж залруулга хийлгэв.

3. Цалин, НДШ-ийн нийт 101.3 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй бүртгэсэн байв. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн зааварт тусгагдсан цалин, НДШ-ийн дансны бичилттэй нийцэхгүй байна. Тухайлбал:

1.Тайлангийн хугацаанд олговол зохих цалинг

ДТ Цалингийн зардал,  
КТ өглөг-Цалингийн тооцоо

Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ.

ДТ Өглөг-Цалингийн тооцооны  
КТ Бусад өглөг-Ажиллагчийн төлөх НДШ  
КТ Бусад өглөг-Ажиллагчийн төлөх ЭМДШ  
КТ Бусад өглөг-Ажиллагчийн төлөх ХХОАТ  
КТ Бусад өглөг-Ажиллагчийн төлөх бусад суутган төлбөр

2. Ажил олгогчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг

ДТ Нийгмийн даатгалын зардал  
КТ өглөг –Нийгмийн даатгалын шимтгэл

Иймд цалин, НДШ-ийн 101.3 сая төгрөгийн тооцоог дээрх дансны зааврын дагуу бүртгэж залруулга хийлгэв.

4. Багаж, техник хэрэгслийн зардлын төсвөөс 5844.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын дансанд шилжүүлсэн бөгөөд тус байгууллагын эд хариуцагч бэлэн мөнгө хүлээн авч хөрөнгө бэлтгэсэн байна. Тус ажил гүйлгээг эд хариуцагч мөнгөн урьдчилгааны тайлан гаргаж тайлагнаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-т тусгагдсан "Мөнгөн урьдчилгааны тайлан" гаргаж анхан шатны бүртгэл хөтлөх зааврыг зөрчиж байна.

Иймд эд хариуцагчаар 5844.0 мянган төгрөгийн зарцуулалтыг "Мөнгөн урьдчилгааны тайлан"-гийн маягтаар гаргуулж залруулга хийлгэв.

Аудитаар илэрсэн 1 алдаанд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 72.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 72.8 мянган төгрөгийг барагдуулсан, 61.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 61.9 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

#### **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Замын-Үүд сум дахь Шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Замын-Үүд сум дахь Шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Шатахууны зардлын батлагдсан төсвийг 2019 онд 796.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Байгууллага нь 2 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд тайлант хугацаанд албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин 5-ыг хэрэглэсэн байна. Нийт 7 автомашинд шатахуун зарцуулсан ба шатахуун зарцуулалтын нормыг тогтоож даргын тушаалаар баталгаажуулаагүй, албан ажлын хэрэгцээнд ашиглаж буй хувийн авто машин нь төрийн үйлчилгээний стандарт, зохих техникийн шаардлагыг бүрэн хангасан эсэх нь тодорхойгүй байна.

Энэ нь "үнэн зөв байдал" батламж мэдэгдэл болон Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар баталсан "Автомашин шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлийг, харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж ажиллах" заалт /Зам тээвэр, хөгжлийн яамны сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-1 дүгээр хавсралт, "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд"- 2 дугаар хавсралт/ Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 даахь заалттай нийцэхгүй байна.

**3.1.2. Эрсдэл:** Төсвийг үр ашиггүй зарцуулах, төсөв хэтрэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Зам тээвэр, хөгжлийн яамны сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-1 дүгээр хавсралт, “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”- 2 дугаар хавсралт, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### Санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,096,013.69	18,989,022.26
33	АВЛАГА	428,628.69	554,500.26
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	428,628.69	0.00
33500	Бусад авлага	0.00	554,500.26
3351	Байгууллагаас авах авлага	0.00	554,500.26
34	УРЬДЧИЛГАА	0.00	4,600,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	0.00	4,600,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.00	4,600,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,667,385.00	13,834,522.00
35400	Хангамжийн материал	12,667,385.00	13,834,522.00
35410	Бичиг хэргийн материал	3,924,740.00	4,396,825.00
35420	Аж ахуйн материал	4,706,796.00	4,935,793.00
35470	Бусад хангамжийн материал	4,035,849.00	4,501,904.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	196,872,830.20	191,387,743.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	196,872,830.20	191,387,743.81
392	Биет хөрөнгө	188,547,676.61	184,448,795.19
39201	Барилга,байгууламж,орон сууц	161,839,780.06	161,839,780.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	3,096,827.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,634,574.47	50,634,574.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	50,634,574.47	50,634,574.47
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	36,118,498.55	41,429,848.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	12,417,385.09	18,123,860.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,567,542.00	5,567,542.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	2,560,758.91	3,167,687.44
39300	Биет бус хөрөнгө	8,325,153.59	6,938,948.62
39301	Програм хангамж	7,297,692.31	7,297,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	4,492,538.72	5,878,743.69
39303	Бусад биет бус хөрөнгө	5,520,000.00	5,520,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	209,968,843.89	210,376,766.07
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	326,852.97	46,666.62
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	326,852.97	46,666.62
41300	Өглөг	326,852.97	46,666.62
41360	Бусад өглөг	326,852.97	46,666.62
41361	Байгууллагад өгөх өглөг	326,852.97	46,666.62
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	209,641,990.92	210,330,099.45
51	Засгийн газрын хувь оролцоо	209,641,990.92	210,330,099.45
51101	Засгийн газрын оруулсан капитал	5,520,000.00	5,520,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	223,876,203.39	224,564,311.92

51210	Өмнөх үеийн үр дүн	223,876,203.39	223,876,203.39
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	688,108.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-19,754,212.47	-19,754,212.47
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	209,968,843.89	210,376,766.07

#### 4.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

##### Санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	149,476,137.60	150,344,020.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,780.00	112,420.00
120	Нийтлэг татварын бус орлого	133,780.00	112,420.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133,780.00	112,420.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	133,780.00	112,420.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	149,342,357.60	150,231,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	143,561,400.00	150,231,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	143,561,400.00	150,231,600.00
1330	Төсвийн захирагчдаас	5,780,957.60	0.00
133003	Хөрөнгийн	5,780,957.60	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	134,030,342.31	149,655,911.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	134,030,342.31	149,655,911.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,800,435.31	149,155,911.47
21.0	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	77,746,517.28	101,589,842.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	73,933,371.31	98,362,295.31
210101	Үндсэн цалин	64,476,171.31	64,665,321.61
210102	Нэмэгдэл	8,957,200.00	33,691,973.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,000.00
210104	Урамшуулал	500,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,813,145.97	3,227,546.77
210201	Тэтгэврийн даатгал	642,651.49	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,170,494.48	3,227,546.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,556,330.80	12,078,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,079,929.00	1,111,054.65
210302	Түлш, халаалт	9,715,401.80	10,407,945.35
210303	Цэвэр, бохир ус	761,000.00	559,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,746,838.00	15,272,103.00
210401	Бичиг хэрэг	3,473,448.00	2,456,548.00
210402	Тээвэр, шатахуун	5,691,445.00	5,556,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,468,352.00	2,570,792.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	89,272.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,113,593.00	2,011,173.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	2,587,968.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,308,350.00	4,896,530.00

**Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	39,000.00
210604	Урсгал засвар	13,308,350.00	4,857,530.00
2107	Томилолт, зочны зардал	1,985,500.00	1,944,000.00
210702	Дотоод албан томилолт	1,985,500.00	1,944,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,360,702.51	1,217,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,700.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,000.00	72,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	764,500.00	764,500.00
210807	Газрын төлбөр	217,502.51	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,096,196.72	12,158,336.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,161,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,096,196.72	10,796,436.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	229,907.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	229,907.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	229,907.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	15,445,795.29	688,108.53
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,307,206.00	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,307,206.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	12,138,589.29	688,108.53

**Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	143,561,400.00	150,231,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,561,400.00	150,231,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	143,561,400.00	150,231,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	143,561,400.00	150,231,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	120,601,400.00	150,231,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	120,601,400.00	150,231,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	120,371,493.00	149,731,600.00
21.0	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	77,848,293.00	101,995,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	74,362,000.00	97,887,000.00
210101	Үндсэн цалин	64,904,800.00	71,241,000.00
210102	Нэмэгдэл	8,957,200.00	26,146,000.00
210104	Урамшуулал	500,000.00	500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,486,293.00	4,108,900.00
210201	Тэтгэврийн даатгал	642,651.49	0.00

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	2,843,641.51	4,108,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,511,000.00	12,078,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,079,929.00	1,111,054.65
210302	Түлш, халаалт	9,670,071.00	10,205,945.35
210303	Цэвэр, бохир ус	761,000.00	761,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,607,000.00	12,352,600.00
210401	Бичиг хэрэг	2,252,715.00	2,498,313.00
210402	Тээвэр, шатахуун	4,557,000.00	5,556,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,027,022.00	3,068,692.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	89,272.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,770,263.00	1,139,973.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,362,000.00	18,944,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	5,844,000.00
210604	Урсгал засвар	14,362,000.00	13,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,944,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,944,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,243,200.00	1,217,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,700.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,000.00	72,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	764,500.00	764,500.00
210807	Газрын төлбөр	100,000.00	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,200,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	229,907.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	229,907.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	229,907.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,960,000.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,960,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,960,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,960,000.00	0.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,960,000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-22,960,000.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
9	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.00	0.00
10	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.00	0.00

## 4.2 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,520,000.00	0.00	0.00	5,520,000.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-19,754,212.47	0.00	-19,754,212.47
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	12,138,589.29	12,138,589.29
2018 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	5,520,000.00	-19,754,212.47	223,876,203.39	209,641,990.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	688,108.53	688,108.53
2019 оын 12 сарын 31-р үлдэгдэл	5,520,000.00	-19,754,212.47	224,564,311.92	210,330,099.45

## 4.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,231,600.00	150,231,600.00	0.00	100.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	150,231,600.00	150,231,600.00	0.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	149,731,600.00	149,731,600.00	0.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,735,700.00	47,735,700.00	0.00	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	97,887,000.00	97,887,000.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	71,241,000.00	71,241,000.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл цалин	26,146,000.00	26,146,000.00	0.00	100.00
210104	Урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,108,900.00	4,108,900.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	4,108,900.00	0.00	4,108,900.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	4,108,900.00	4,108,900.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,078,000.00	12,078,000.00	0.00	100.00

Замын-Үүд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	987,000.00	1,111,054.65	-124,054.65	112.57
210302	Түлш, халаалт	10,330,000.00	10,205,945.35	124,054.65	98.80
210303	Цэвэр, бохир ус	761,000.00	761,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,352,600.00	12,352,600.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,846,200.00	2,498,313.00	-652,113.00	135.32
210402	Тээвэр, шатахуун	6,352,600.00	5,556,350.00	796,250.00	87.47
210403	Шуудан,холбоо, интернэтийн төлбөр	2,818,200.00	3,068,692.00	-250,492.00	108.89
210405	Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	180,000.00	89,272.00	90,728.00	49.60
210406	БҮТЭЗүйлс	1,155,600.00	1,139,973.00	15,627.00	98.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,944,000.00	18,944,000.00	0.00	100.00
210601	Багаж,техник хэрэгсэл	5,844,000.00	5,844,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	13,100,000.00	13,100,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,944,000.00	1,944,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,944,000.00	1,944,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,217,100.00	1,217,100.00	0.00	100.00
210802	Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,600.00	72,600.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	764,500.00	764,500.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	6,000.00	6,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150,231,600.00	150,231,600.00	0.00	100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	150,231,600.00	150,231,600.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	150,231,600.00	150,231,600.00	0.00	100.00